



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 14




Төлбөрийн тэнцэл 2021 оны 12 дугаар сард 214.8 сая америк долларын ашигтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 тэрбум америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оноос 1.2 (2.7 дахин) тэрбум америк доллароор өсжээ.

Уг өсөлтөд анхдагч орлогын алдагдал өмнөх оноос 823.6 сая америк доллароор өсөж, 2.1 тэрбум америк доллар болсон нь голлон нөлөөлсөн байна.

Урсгал данс 2021 оны 11 дүгээр сард 464.4 сая америк долларын ашигтай байсан бол 12 дугаар сард 722.8 сая америк долларын алдагдалтай гарчээ.

ЗУРАГ 1. УРСГАЛ ДАНС, сая америк доллароор, сараар



Үйлчилгээний худалдааны орлого 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 785.1 сая америк доллар, зарлага 2.2 тэрбум америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 130.2 сая америк доллароор, зарлага 76.2 сая америк доллароор тус тус өссөн байна.

Үйлчилгээний худалдааны алдагдал 2021 онд өмнөх оноос 53.9 сая америк доллароор буурч, 1.4 тэрбум америк доллар болжээ.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, салбараар, сая америк доллароор

Үзүүлэлт	2020		2021*	
	XII	I-XII	XII	I-XII
Үйлчилгээ	- 134.7	- 1 450.2	- 208.2	- 1 396.3
Кредит	66.9	654.9	89.9	785.1
Дебит	201.6	2 105.2	298.1	2 181.4
Тээвэр	- 6.6	- 212.1	2.4	10.1
Кредит	42.2	384.0	66.1	537.6
Дебит	48.8	596.1	63.7	527.5
Аялал	- 34.1	- 520.6	- 50.8	- 579.7
Кредит	1.6	29.4	1.9	20.3
Дебит	35.7	549.9	52.7	600.0
Бусад үйлчилгээ	- 93.9	- 717.5	- 159.8	- 826.8
Кредит	23.1	241.6	21.9	227.2
Дебит	117.1	959.1	181.7	1 053.9

Хөрөнгийн данс 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 126.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оноос 23.3 сая америк доллароор өсжээ. Мөн 2021 оны 12 дугаар сард 10.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 0.2 сая америк доллароор өссөн байна.

Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.7 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оноос 242.5 сая америк доллароор өсжээ. Мөн санхүүгийн дансны тэнцэл 2021 оны 11 дүгээр сард 392.1 сая америк долларын алдагдалтай байсан бол 12 дугаар сард 877.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 1.3 тэрбум америк доллароор өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сая америк доллароор

Үзүүлэлт	2020		2021*		Төлбөрийн тэнцэл 2020 онд 786.9 сая америк долларын ашигтай байсан бол 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 1.0 тэрбум америк долларын алдагдалтай гарсан байна. Харин төлбөрийн тэнцэл 2021 оны 12 дугаар сард 214.8 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 82.9 сая америк доллароор өсжээ.
	XII	I-XII	XII	I-XII	
Урсгал данс	- 84.9	- 674.6	- 722.8	- 1 824.7	
Хөрөнгийн данс	8.8	102.8	10.1	126.1	
Санхүүгийн данс	- 801.0	- 1 504.2	- 877.5	- 1 746.7	
Алдаа болон орхигдуулга	52.8	- 145.6	49.9	- 269.7	
Нөөц хөрөнгө	777.6	786.9	214.8	- 221.6	

Ойлголт, тодорхойлолт

Төлбөрийн тэнцэл: Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

Урсгал данс: Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс: Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс: Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед "+" буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед "-" буюу ашигтайг илэрхийлнэ.

Цэвэр нөөц: Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

Шууд хөрөнгө оруулалт: Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.



Эх үүсвэр:

Монголбанк

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 3 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн албаны
статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212